

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2009 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт				Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
			Хүн хүч	Хөрөнгө санхүү	Хугацаа	Гүйцэтгэлийн үзүүлэлт		
ТУЛГУУР НЭГ. ЁС ЗҮЙТЭЙ МАНЛАЙЛАЛ								
1	Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох	1.1. Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж авлигыг үл тэвчих, ёс зүйтэй байх, шударга ёсыг эрхэмлэн ажиллахаа олон нийтэд мэдэгдэл хийх	Хүн/өдөр	Шаардлага гүй	3-р улиралд	<ul style="list-style-type: none"> Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хандаж мэдэгдэл хийсэн байх Олон нийтэд хүрсэн байх 	х/а М.Энх-Амгалан, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нар	Цагдаагийн байгууллагын ажилтнууд болон олон нийтэд шударгаар ажиллаж, амьдрах итгэл үнэмшлийг бий болгоно.
		1.2. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах тухай Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд нэг заалт болгон оруулах, төсөв батлуулахад энэ ажилд зарцуулахаар тодорхой хэмжээний хөрөнгийг тусгуулж байх	Хүн/өдөр /Мөнгөний дүн	4-р улиралд	<ul style="list-style-type: none"> Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нэг заалт болгон байгууллагын төлөвлөгөөнд оруулсан байх Шаардагдах хөрөнгийг төсвийн багцад суулгах саналыг холбогдох газарт тавьж шийдвэрүүлсэн байх Батлагдсан төсвийг зарцуулж ажилласан байх 	х/а Ц.Арвинбуудай, х/а Ч.Энх-Амгалан	
		1.3. Цагдаагийн байгууллагын аливаа үйл ажиллагаанд оролцоходоо сонирхлын зөрчлийг мэдүүлэх тогтолцоог төлөвшүүлэх /Жишээ нь тендэрийн үнэлгээний хорооны гишүүд, хэрэг, зөрчил шалгаж байгаа цагдаагийн алба хаагчид сонирхлын зөрчилгүйгээ урьдчилан мэдүүлэх/	багаар	+	жилдээ	<ul style="list-style-type: none"> Сонирхлын зөрчлийг мэдүүлдэг тогтолцоог төлөвшүүлсэн байх Хуульд нийцсэн байх Хуулийн хэрэгжилтийг хангасан байх 	х/а А.Дулаанжаргал, х/а Ч.Энх-Амгалан, х/а Ц.Азбаяр, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	
ТУЛГААР ХОЁР. ХУВЬ ХҮНИЙ ШУДАРГА БАЙДАЛ								
2	Шударга ёс, эрхэмлэх зүйлс болох ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх	2.1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2002 оны 08 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм” -ийг шинэчлэн батлуулах	багаар		3-р улиралд	<ul style="list-style-type: none"> Төслийг холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, санал авсан байх АТГ-аас санал авсан байх Батлагдсан байх Нийт ажилтнуудад хүргэсэн байх Хариуцлага тооцох мехнаизмыг бүрдүүлсэн байх 	х/а Ц.Арвинбуудай, д/х Б.Амгаланбаатар, д/х Ж.Ганбаатар	Хувь хүний шударга байдалд ахиц гарна.
		2.2. Алба хаагчдын ажлын байрны тодорхойлолт болон үр дүнгийн гэрээнд шударга ёсны шалгуурыг тусгах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар заалт оруулж, үр дүнгийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт болгож байх	багаар		3-р улиралд	<ul style="list-style-type: none"> Ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд өөрчлөлт орсон байх Дүгнэх шалгуур үзүүлэлт тодорхой болсон байх Шалгуур үзүүлэлтийг баримтлан үр дүнгийн гэрээг дүгнэсэн байх 	х/а Ц.Арвинбуудай, х/ч Ц.Азбаяр, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	

3	Алба хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх, сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр сургалт, семинар, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах	3.1. Үйл ажиллагаандаа голлон дагаж мөрддөг хууль, тогтоол, захирамж, албан даалгавар, дүрэм, журам, заавар зэрэг хууль эрхийн актуудыг судлуулж, мөрдүүлэх	Хүн/өдөр	+	тухай бүр	<ul style="list-style-type: none"> Сургалтыг холбогдох байгууллагатай хамтрах буюу эсвэл бие даан зохиосон байх Сургалтад бүрэн болон хэсэгчлэн хамрагдсан байх Сургалт давтамжтай байх Сургалт үр дүнгээ өгсөн байх 	д/х Б.Амгаланбаатар, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	
		3.2. Харьцааны соёл, стресс, эсдлээс гарах арга зам, иргэдтэй харьцахдаа тэдний сэтгэл зүйд тулгуурлан харьцах дадал бий болгох						
		3.3. Авлигын тухай ойлголт, хор уршиг, авлигыг үл тэвчих, шударга байх сэтгэхүйг алба хаагчдад төлөвшүүлэх						
		3.4. Эрүүл, зөв амьдрахуйн хэв маягийг хэвшүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээрх сургалт /цаг ашиглалт, биеийн тамир, эрүүл мэндийн, архи дан согтуурахаас урьдчилан сэргийлэх/						
		3.5. Цагдаагийн академийн сургалтын төлөвлөгөөнд “Авлига, түүний ойлголт, урьдчилан сэргийлэх арга зам” гэсэн сэдэв оруулах, онол практикийн бага хурал зохион байгуулах	Хүн/өдөр	+	4-р улиралд	<ul style="list-style-type: none"> Төлөвлөгөөнд тусгагдаж хичээл заагдсан байх Бага хурал зохион байгуулагдсан байх 	х/а М.Энх-Амгалан, х/а Ц.Эрдэнэбат	Алба хаагч, сонсогчид авлигын талаарх мэдлэгтэй болно.

ТУЛГУУР ГУРАВ. ТОГТОЛЦООНЫ ШУДАРГА БАЙДАЛ

4	Авлигыг үүсгэж болзошгүй дүрэм, журмыг хянах, хариуцлагын тогтолцоог бий болгох	4.1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам, заавруудыг нягтлан үзэж авлигад өртөх эрсдэл, хүнд суртал чирэгдэл учруулж болох нөхцөл байдлыг илрүүлж, өөрчлөх замаар ил тод, түргэн шуурхай, хариуцлага тооцох боломжтой байх эрх зүйн орчинг боловсронгуй болгох	багаар	+	жилдээ	<ul style="list-style-type: none"> Албадын төлөөллийг хамруулсан байх Тодорхой санал, дүгнэлт гаргаж хэрэгжүүлсэн байх Өөрчилсөн дүрэм, журмын нэр, холбогдох заалтыг бичих 	х/а Ц.Арвинбуудай, д/х Ж.Ганбаатар, албад	Тогтолцооны шударга байдал хангагдана.
		4.2.Цагдаагийн байгууллагаас иргэдэд үйлчлэх стандартыг боловсруулан батлуулж мөрдүүлэх	багаар		жилдээ	<ul style="list-style-type: none"> Албадаас санал авсан байх, Олон улсын туршлага судалсан байх Стандартыг боловсруулж, батлуулсан байх Нэгжид хүргүүлсэн байх 	х/а А.Даваахүү, д/х Ж.Ганбаатар	
		4.3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бол бэлэг, зээл авч өгөллөх, дайллага цайллагатай холбоотой дүрэм баталж мөрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх	багаар		жилдээ	<ul style="list-style-type: none"> Дүрэм гаргах харилцааг тодорхойлсон байх Тухайн харилцааг зохицуулах шаардлагатай дүрэм журам батлагдсан байх 	х/а Ч.Энх-Амгалан, д/х Ж.Ганбаатар	
		4.4. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа тохиолдолд тэдний эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах тогтолцоог хэвшүүлэх	Хүн/өдөр	+	тухай бүр	<ul style="list-style-type: none"> Цагдаагийн байгууллага, алба хаагчдын хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалсан байх 	х/а Ц.Арвинбуудай, д/х Ж.Ганбаатар	

		4.5. Алба хаагчдыг авлигад өртүүлэхгүй байх боломж нөхцлийг хангах зорилгоор ажлын ачааллыг багасгах, тэнцвэржүүлэх, цалин хангамжийг нэмэгдүүлэх санал боловсруулж холбогдох газарт уламжлан шийдүүлэх, нийгмийн асуудлыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	багаар	+	жилдээ	<ul style="list-style-type: none"> Ажлын ачаалал харилцан адилгүй байгааг тэнцвэржүүлсэн байх Цалин нэмэгдүүлсэн байх, зарим алба хаагчийг урамшуулж шагнасан байх Нийгмийн тодорхой асуудлыг шийдвэрлэж өгсөн байх 	х/а Ц.Арвинбуудай, х/а Ч.Энх-Амгалан, д/х Б.Амгаланбаатар, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	
		4.6. Цагдаагийн байгууллага дотооддоо цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, иргэдэд байгууллагын ажил, үйлчилгээг ил тод шуурхай хүргэх, шаардлагатай мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх	Хүн/өдөр		жилдээ	<ul style="list-style-type: none"> Дотооддоо мэдээллийг цахим хэлбэрээр солилцож хэвших Шаардлагатай ажил үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн байх 	х/а Ж.Бумнанжид, х/а Л.Даваажав, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	
		4.7. Цагдаагийн байгууллагын вэб сайт дахь мэдээ, мэдээллийг эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тогтмол баяжуулах, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэх, сурталчлах, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан санал, гомдлыг электрон хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэж хариу өгч ажиллах	Хүн/өдөр	Интернэтийн төлбөр, түрээс	тухай бүр	<ul style="list-style-type: none"> Хэрэгцээтэй мэдээллийг тогтмол оруулж, баяжуулсан байх Иргэдэд үйл ажиллагааг хүргэсэн байх Санал гомдлыг мэйлээр хүлээн авч, шийдвэрлэж хариу өгсөн байх 	х/а Т.Сайнжаргал, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	
		4.8. Цагдаагийн байгууллагын тухайн албан тушаалд олон жил ажилласан, авлигад өртөж болзошгүй албан тушаалд ажиллаж байгаа алба хаагчдыг сэлгэн ажиллуулах журмыг шинэчлэн батлуулах, шаардлагатай бол сэлгэн ажиллуулах саналыг ЦЕГ-ын удирдлагад тавьж шийдвэрлүүлж байх, цагдаагийн байгууллагын хэмжээнд авлигад өртөж болзошгүй албан тушаал, ажил үйлчилгээний жагсаалт, эдгээртэй холбогдсон судалгааг гаргах	багаар		3-р улиралд	<ul style="list-style-type: none"> Олон жил ажилласан алба хаагч, мөн авлигад өртөж болзошгүй албан тушаал, ажил үйлчилгээний судалгааг гаргасан байх Журмыг боловсруулж батлуулсан байх Журмыг мөрдлөг болгон ажилласан үр дүнг тусгагсан байх 	д/х Б.Амгаланбаатар	
		4.9. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн гэрээ, хэлэлцээр байгуулахдаа заавал авлигын эрсдлээс зайлсхийх заалт оруулж байх	багаар		тухай бүр	<ul style="list-style-type: none"> Гэрээний нэрийг зааж өгсөн байх Хууль нийцсэн байх Авлигын эсрэг заалт оруулсан байх 	х/а Ц.Арвинбуудай, д/х Ж.Ганбаатар	
5	Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж жиллах	5.1. Цагдаагийн байгууллагад ажилд авах, дэвшүүлэх, суралцах зэрэг сонгон шалгаруулах журмуудыг нийтэд ил тод байлгах, оролцогч бүрийг ижил тэгш мэдээллээр хангаж шударгаар шийдвэрлэх, эрх тэгш байдлыг хангах боломжийг бүрдүүлэх	Хүн/өдөр		жилдээ	<ul style="list-style-type: none"> Хүний нөөцийг ил тод байдлаар шударгаар бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг алба хаагч нар бүрэлдүүлсэн байх 	д/х Б.Амгаланбаатар, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт хангагдана.
		5.2. Иргэдэд үйлчилгээ үзүүлдэг танхимд авлига, хүнд сурталын эсрэг сурталчилгааг байрлуулах, иргэдийг хүлээн авч уулзах, цагийн хуваарь, уулзах ажилтны овог нэр, харилцах утсыг тодорхой бичиж, байгууллагын мэдээллийн самбарт болон цахим хуудсанд байршуулах,	багаар	+	3-р улиралд	<ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг сурталчилгааг байрлуулсан байх Цагийн хуваарь, овог, нэр, харилцах утас, хариуцах ажлыг мэдээллийн самбар болон цахим хууспанд бичсэн байх 	албад, төв, орон нутгийн газар, хэлтэс	

		5.3. Цагдаагийн байгууллагаас иргэдэд үйлчлэх үйлчилгээг хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, хүнд суртал чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн сар бүр “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулж, иргэдийн санал гомдлыг хүлээн авч, шуурхай шалгаж шийдвэрлэх	багаар	+	сар бүр	<ul style="list-style-type: none"> • Арга хэмжээг үр дүнг зохион байгуулсан байх • Иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэсэн байх, тэдэнд үйлчилсэн байх 	албад, төв, орон нутгийн газар, хэлтэс	
		5.4. Цагдаагийн байгууллагын 2009 оны төсөв, түүний зарцуулалт, бараа үйлчилгээ худалдан авалт, тайлан зэрэг мэдээллийг цахим болон бусад зохистой хэлбэрээр нийтэд түгээх ажлыг хэвшүүлэх	багаар		жилдээ	<ul style="list-style-type: none"> • Төсөв, зарцуулалтын тайлан болон бараа үйлчилгээ худалдан авалт зэрэг мэдээллийг нийтэд түгээсэн байх • Цахим хэлбэрээр түгээсэн байх 	х/а Ч.Энх-Амгалан, х/а Т.Сайнжаргал	
		5.5. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэлтийн байдлыг хянах цахим, нээлттэй системийг бий болгон нэвтрүүлэх	3-р улиралд			<ul style="list-style-type: none"> • Системийг боловсруулсан байх • Нэвтрүүлж ашигласан байх 	х/а Ж.Бумнанжид, х/а Х.Энхжаргал	
		5.6. Цагдаагийн байгууллагын ил тод байдлыг сайжруулахын тулд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлыг олон нийтэд түгээх			тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлыг нийтэд түгээсэн байх 	х/а Ж.Бумнанжид, х/а Т.Сайнжаргал, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	

ДӨРӨВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ БОЛОН ТАСЛАН ЗОГСООХ

6	Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах	6.1. Авлигын эсрэг хууль, хөтөлбөр, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг улирал бүр гаргаж Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх	Хүн/өдөр		улирал бүр	<ul style="list-style-type: none"> • Хууль, хөтөлбөр, болон төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрэгжсэн байх • Тодорхой албан тушаалтанд хариуцуулж, ажлын байрны тодорхойлолтод тусгасан байх • Тайлан, мэдээ хугацаандаа хүргэгдсэн байх 	х/а М.Энх-Амгалан, х/а Ж.Бумнанжид	Хариуцлагын тогтолцоо бий болно.
		6.2. Цагдаагийн байгууллагын алба хаагч бүр авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон тохиолдолд холбогдох албан тушаалтан, байгууллагад заавал мэдээлдэг байх, мөн авлига өгөхийг санал болгосон, өгөхөөр завдсан тухай илтгэсэн үнэнч, шударга алба хаагчийг урамшуулах замаар алба хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх итгэл үнэмшлийг төрүүлэх	Хүн/өдөр		тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Нэн даруй мэдэгдсэн байх • Урамшуулсан байх 	албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс	
		6.3. Алба хаагчтай холбоотой авлигын талаарх мэдээлсэн этгээд, мэдээллийн нууц байдлыг хангах журмыг бий болгож, мөрдүүлэх	багаар		3-р улиралд	<ul style="list-style-type: none"> • Журмыг боловсруулж санал авсан байх • Журмыг батлуулж мөрдүүлсэн байх 	х/ч Ц.Азбаяр	

	6.4. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын авлигын түвшинг тогтоох зорилгоор Авлигатай тэмцэх газартай хамтран иргэд, цагдаагийн алба хаагч нараас тандалт, судалгааг явуулж түүний мөрөөр ажлаа төлөвлөж, ажил зохиох, судалгааг тодорхой хугацааны давтамжтайгаар хийж хэвших	багаар	+	3-р улиралд	<ul style="list-style-type: none"> Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын чиг баримжааг тодорхойлсон байх Судалгааны дүнг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн байх 	х/ч Ц.Азбаяр
	6.5. Алба хаагчдын сахилгын байдал, алба хаагчийн үйлдсэн авлигын гэмт хэрэг, түүнд оногдуулсан ял шийтгэлийн шалтгаан нөхцөлийг судалж, мэдээллийг бие бүрэлдэхүүнд шуурхай мэдээлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах	Хүн/өдөр		Улирал бүр	<ul style="list-style-type: none"> Бие бүрэлдэхүүнд мэдээлсэн байх Урьдчилан сэргийлэх ажил зохиосон байх 	х/а М.Энх-Амгалан, х/ч Ц.Азбаяр
	6.6. Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн хууль бус үйлдэл, авлига, хүнд суртлын талаарх 126 дугаарын утсаар /саналын хайрцаг, дэвтэр/ ирсэн гомдол, мэдээллийн мөрөөр шалгалт явуулж, шийдвэрлэж байх			Тухай бүр	<ul style="list-style-type: none"> Гомдол, мэдээллийн мөрөөр тодорхой ажил зохиосон байх Мэдээлэгч ба мэдээллийн нууцлалыг хангах талаар баталгаа авсан байх Задруулсан тохиолдолд хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжсэн байх 	х/ч Ц.Азбаяр, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс
	6.7. 3 сарын цалингаас илүү хэмжээний өр зээлтэй алба хаагчдын судалгаа гаргаж, хяналт тавьж, тэднийг дэмжиж ажиллах	Хүн/өдөр		3-р улиралд	<ul style="list-style-type: none"> Судалгааг гаргасан байх Хяналт тавьж, үүсч болох эрсдлээс урьдчилан сэргийлсэн байх Алба хаагчдын ахуй амьдралд дэмжлэг үзүүлсэн байх 	х/ч Ц.Азбаяр, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс
	6.8. Цагдаагийн байгууллага, нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах	Төлөвлөгөөний дагуу			<ul style="list-style-type: none"> Шалгалт хийгдсэн байх Дутагдлыг засуулсан байх 	х/ч Ц.Азбаяр
	6.9. Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагч нар иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилж байгаа байдлыг шалгаж үнэлэлт дүгнэлт өгч ажиллах			Төлөвлөгөөний дагуу	<ul style="list-style-type: none"> Шалгалт хийгдсэн байх Дутагдлыг засуулсан байх 	х/ч Ц.Азбаяр
	6.10. Цагдаагийн алба хаагчийн авлигад өртсөн тухай гомдол, мэдээлэл, хэвлэл, нийтлэлийн мөрөөр албаны шалгалтыг явуулах			Тухай бүр	<ul style="list-style-type: none"> Шалгалт хийгдсэн байх Дутагдлыг засуулсан байх 	х/ч Ц.Азбаяр, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс
	6.11. Байгууллагын салбар зөвлөлөөс дотоодын хяналтыг ил ба далд аргаар зохион байгуулах			байнга	<ul style="list-style-type: none"> Шалгалт хийгдсэн байх Дутагдлыг засуулсан байх 	албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс
	6.12. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай байнга хамтран ажиллах	+		жилдээ	<ul style="list-style-type: none"> Төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулахдаа хамтран ажилласан байх 	албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс
	6.13. “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилт, сайжруулах арга зам” сэдэвт удирдах ажилтан нарын семинар,			3-р улиралд	<ul style="list-style-type: none"> Удирдах ажилтан нарын семинар, зөвлөгөөнийг зохион байгуулсан байх Авлигаас урьдчилан сэргийлэх зохион байгуулах ажлын арга зүйн мэдээллээр, удирдлага зохион байгуулалтаар хангасан бах 	х/а М.Энх-Амгалан, х/а Ж.Бумнанжид, х/ч Ц.Азбаяр

		зөвлөгөөнийг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулах					
		6.14. Салбар зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцах албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгаж өгөх			жилдээ	<ul style="list-style-type: none"> Ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусгаж өгсөн байх 	х/а М.Энх-Амгалан, албад, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс
		6.15. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиогдож буй форум, семинар, зөвлөгөөнд оролцох			жилдээ	<ul style="list-style-type: none"> Форум, семинар, зөвлөгөөнд оролцсон байх Мэдээллээр хангагдсан байх 	х/а М.Энх-Амгалан, х/а Ж.Бумнанжид
		6.16. Салбар зөвлөлөөс авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажлыг нэгжид шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх, дүнг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх			жилдээ	<ul style="list-style-type: none"> Шалгаж үнэлэлт дүгнэлт өгсөх байх Хуралдаанаар хэлэлцүүлсэн байх 	х/а М.Энх-Амгалан, х/а Ж.Бумнанжид, х/ч Ц.Азбаяр
		6.17. Цагдаагийн байгууллагын салбар зөвлөлийн хуралдааны зөвлөмжийг цагдаа, дотоодыг цэргийн нийт бие бүрэлдэхүүнд хүргүүлж, биелэлтэд хяналт тавих			жилдээ	<ul style="list-style-type: none"> Зөвлөмжийг гарган хүргүүлсэн байх 	х/а М.Энх-Амгалан, х/а Ж.Бумнанжид, х/ч Ц.Азбаяр
		6.18. Цагдаагийн байгууллагын шинээр орсон алба хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх			тухай бүр	<ul style="list-style-type: none"> Хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд хүргүүлсэн байх 	х/ч Ц.Азбаяр

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР